



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 18

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 13,762,316 (Арван гурван сая долоон зуун жаран хоёр мянга гурван зуун арван зургаа) төгрөгийн балансын үнэтэй, 12,558,113,34 (Арван хоёр сая таван зуун тавин найман мянга нэг зуун арван гурван төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй блокон складыг газаргүйгээр хавсралтад заасны дагуу нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан), Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхэд хяналт тавих

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчuluун)-д үүрэг болгосугай.





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт

Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтанд орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа / жилээр /	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			ХЭМ ЖИХ НЭГЖ	БИЕТ ХЭМЖЭЭ							
1	Блокон склад	Агуулах	М.КВ	173	1991	60	1	13,762,316	1,204,202,79	12,558,113,34	4,936,000
							1	936,210,32 (есөн зуун гучин зургаан мянга хоёр зуун арван төгрөг гучин хоёр мөнгө) төгрөг	150,834,80 (нэг зуун тавин мянга найман зуун гучин дөрвөн мөнгө наян мөнгө) төгрөг	785,375,52 (долоон зуун наян таван мянга гурван зуун далан төгрөг хоёр тавин төгрөг мөнгө) төгрөг	4,681,000 (дөрвөн сая зургаан зуун наян нэг мянга) төгрөг
								Нийт дүн			